



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!


165 /165/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.10.27

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 ДУГААР АНГИД АЖИЛЛАЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайдын баталсан удирдамжийн хүрээнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа З.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг БХЯ-ны харьяа байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад ажиллаж байна. Ажлын хэсэг Улсын төсвийн болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын явц болон гүйцэтгэлтэй танилцахаас гадна төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэл ажил, Батлан хамгаалах сайдын 2021 оны А/230 дугаар тушаалын хэрэгжилттэй танилцаж үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байгаа юм. Энэ хүрээнд тус ажлын хэсэг өнөөдөр Зэвсэгт хүчний 017, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиудад ажиллаж байна.

Энэ үеэр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа З.Болдбаатар хэлэхдээ "Өнөөдрийн байдлаар Улсын төсвийн болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын 90 орчим хувь дуусаж ашиглалтад орсон бол үлдэж байгаа 10 орчим хувь нь он дамжин хийгдэх төлөвлөгөөт ажлууд байна.

Мөн ажлын хэсгийн гол зорилго нь Батлан хамгаалах салбарын хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн үйл ажиллагаа яг тухайн газраа хэрхэн явагдаж байгаатай танилцах юм. Түүнчлэн ажиллаж байгаа байгууллага, нэгтгэл ангийн бие бүрэлдэхүүнд Батлан хамгаалахын сайдын зүгээс баримталж буй бодлого, хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл олгоход чиглэгдэж байна. Тухайлбал, ойрын хугацаанд буюу ирэх 11 дүгээр сарын 15 гэхэд 200 цэргийн байрыг ашиглалтад оруулах, цэргүүдийг хэрэглээний халуун, хүйтэн устай болгох, шинээр цэргийн албанд ирээд байгаа оюутан цэргүүдийн хичээлийг тасалдуулахгүй байх үүднээс цахимаар хичээлд нь хамруулж байхын тулд ангийн интернэтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг олон төрлийн мэдээллээр хангахын зэрэгцээ чиглэсэн үүргүүдийг өгч ажиллаж байна" гэлээ.

Ажлын хэсэг дээрх хоёр ангиас гадна БХЯ-ны харьяа байгууллагууд болон 011, 015, 032, 084, 150, 303 дугаар ангиуд ажиллаад байгаа юм.

Түүхэнд энэ өдөр

1941 он:
ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны 18 тоот тушаалаар Улаанбаатар хотын гарнизоны ангиудыг байлдаанд бэлэн болгож, бүх анги ба албан газруудын дарга, улс төрийн тушаалтан нарыг хуарангийн байдалд оруулжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	🌧️ -11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,850.0	2,853.0
EUR 🇪🇺	3,315.0	3,325.0
CNY 🇨🇳	445.0	446.0
RUB 🇷🇺	39.90	41.60
JPY 🇯🇵	24.76	25.31
KRW 🇰🇷	2.34	2.47

ЗУРХАЙ

2021.10.27 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 22/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдоно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.29-17.43

БАРИЛДЛАГА:
Үл зохилдох
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Нэр өнгө
Суудал:
Ус

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн бамогой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, хур оруулах, дархны үйлд сайн.

Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа

"ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АВАРГА ТОГООЧ-2021" ТЭМЦЭЭН ӨНӨӨДӨР ЭХЭЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газраас алба хаагч бүр өөрийн хүлээсэн үүрэгт ажилдаа мэргэших, ур чадвараа нэмэгдүүлэн ажиллах зорилтыг хэрэгжүүлэх үүднээс мэргэжил бүрд чиглэгдсэн тодорхой, бүтээлч ажлуудыг зохион байгуулсаар ирсэн. Энэ хүрээнд Зэвсэгт хүчний аварга тогооч шалгаруулах тэмцээнийг зохион байгуулдаг уламжлалтай.

"Зэвсэгт хүчний тогооч-хоол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо" ТББ, "Монголын тогооч нарын холбоо"-той хамтран зохион байгуулсан эл тэмцээн өнөөдөр Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн байрлалд нээлтээ хийлээ.

Энэ жилийн тэмцээнд Зэвсэгт хүчний 12 ангийн 40 гаруй мэргэжлийн тогоочид оролцож ур чадвар, авхаалж самбаагаа дайчлан өрсөлдөх юм.

Тэмцээний Ерөнхий шүүгчээр ЗХЖШ-ын Материал, техникийн газрын Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа С.Баяр-Очир, шүүгчээр тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Батням, "Монголын тогооч нарын холбоо"-ны гүйцэтгэх захирал Д.Батзул, сургалт хариуцсан, захирал Л.Долгор нар ажиллаж аж.

Зэвсэгт хүчний аварга

тогооч шалгаруулах тэмцээний зорилго нь Хүнс, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан эрүүл ахуйн зохистой дадлыг Зэвсэгт хүчний анги, салбарт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний 2010-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний тогооч нарын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний сүүлийн үеийн арга, технологид харилцан суралцах, цэргийн алба хаагчдад эрүүл хоол хүнсээр үйлчлэх үйлчилгээг сайжруулах, анги, салбаруудын мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд оршиж байгааг нээлтийн үеэр зохион байгуулагчид онцоллоо.



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
350,604 +1095

ЭДГЭРСЭН
530,687

НАС БАРСАН
1,593 +6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5914 +102

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
271

ЭДГЭРСЭН
5557

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 245,275,484

Эдгэрсэн
Нийт: 222,349,743

Нас барсан
Нийт: 4,978,725

Цахим шууданд

ТӨВ АЙМГИЙН ЗУУН МОД СУМЫН ОНЦГОЙ КОМИССООС 1000 ШИРХЭГ МАСК ХАНДИВЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Дэлхий нийтэд тархаад байгаа коронавирус (COVID-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх эрсдэлт нөхцөл байдлыг даван туулахад эв санаа нэгтэй

байгаага илэрхийлэн Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд Төв аймгийн Зуун мод сумын онцгой комиссоос 1000 ширхэг маск, ариутгалын төхөөрөмжийн хамт хандивлалаа.

ШААРДЛАГАТАЙ ХУЯГТ ТАНКНУУДЫГ ТЕХНИКИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАВ



Мөн Монгол Улс, Оросын холбооны Улсын Батлан хамгаалахын салбарын цэрэг техникийн хамтын ажиллагааны хүрээнд Оросын холбооны Улсын Батлан хамгаалах яамны төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн засварлах, шинэчлэх, сэргээн сайжруулах шаардлагатай хуягт танкийн техникт үзлэг явууллаа.

**Хошууч
Д.ДОЛГОРЖАВ**



Таны сонорт

БАТЛАН ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНД “ТӨВИЙН ДАРГА”-ЫН АЛБАН ТУШААЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Ажлын байрны зорилго:

Цэргийн шинжлэх ухааны онол, практик, хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлуудыг судалж, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх, цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагыг мэдээллээр хангах.

Тавигдах ерөнхий шаардлага:

• Команд-штаб, оператив-тактикийн мэргэжилтэй;

• Магистраас дээш боловсролын зэрэгтэй;
• Их, дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллагад тасралтгүй 5-с доошгүй, төрийн албанд 12-аас доошгүй жил ажилласан байх;

• Гадаад хэлийг (Орос, Англи хэлийг) судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх.

Бүрдүүлэх материал:

• Өргөдөл;
• Төрийн алба хаагчийн анкет (1 дүгээр

маягтаар);
• Боловсролын зэргийг гэрчилсэн баримт (дипломууд);

• Иргэний болон офицерын үнэмлэхийн хуулбар;

• Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

• Сонгон шалгаруулалтад орохыг зөвшөөрсөн ажиллаж буй байгууллагын бичгээр гарсан зөвшөөрөл;

• Бүртгэлийн хураамж /тухай бүрд тогтоон зарлана/;
• Бусад шаардлагатай

бичиг баримт.

Бүртгэл:

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хүртэл ҮБХИС-ийн штабын 3 дугаар давхар, 303 тоот өрөөнд явагдана.

Холбогдох албан тушаалтан:

БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Т.Соронзонболд, Референт-Эрдэм шинжилгээний ажилтан, ахмад Ж.Базарсүрэн. Утас: 453942, 90881133

БАТЛАН ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байрны зорилго:

Цэргийн шинжлэх ухааны онол, хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлуудыг судалж, үндэсний цэргийн урлаг, зэвсэглэл, техник, хэрэгслийг зохион бүтээх, үйлдвэрлэх, сайжруулах, технологи нутагшуулах талаар судалгаа, туршилт явуулж, инновацыг хөгжүүлэх, цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагыг мэдээллээр хангах.

Тавигдах ерөнхий шаардлага:

• Цэргийн дээд боловсролтой / инженерийн зохиох боловсролтой;

• Магистраас дээш боловсролтой;

• Цэргийн анги, байгууллагад тасралтгүй 5-аас доошгүй, төрийн албанд 8-аас доошгүй жил ажилласан байх;

• Орос хэлийг хүрээнд мэргэжлийн түвшинд эзэмшсэн, англи хэлний зохиох боловсролтой байх.

Бүрдүүлэх материал:

• Өргөдөл;
• Төрийн алба хаагчийн

анкет (1 дүгээр маягтаар);

• Боловсролын зэргийг гэрчилсэн баримт (дипломууд);

• Иргэний болон офицерын үнэмлэхийн хуулбар;

• Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

• Сонгон шалгаруулалтад орохыг зөвшөөрсөн ажиллаж буй байгууллагын бичгээр гарсан зөвшөөрөл;

• Бүртгэлийн хураамж /тухай бүрд тогтоон зарлана/;
• Бусад шаардлагатай

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хүртэл ҮБХИС-ийн штабын 3 дугаар давхар, 303 тоот өрөөнд явагдана.

Холбогдох албан тушаалтан:

БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Т.Соронзонболд, Референт-Эрдэм шинжилгээний ажилтан, ахмад Ж.Базарсүрэн. Утас: 453942, 90881133

Бүртгэл:

БАТЛАН ХАМГААЛАХ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНД ТҮҮХЧ, АРХЕОЛОГИЧ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байрны зорилго:

Түүхийн шинжлэх ухааны онол, хөгжлийн чиг хандлага, түүх археологийн судалгааны үндсэн асуудлуудыг судалж, түүх, археологи, соёлын үнэт өвийг, сэргээн, сайжруулах, хадгалан хамгаалах талаар судалгаа, явуулж, инновацыг хөгжүүлэх хөгжүүлэх, цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагыг мэдээллээр хангах.

Тавигдах ерөнхий шаардлага:

• Цэргийн дээд боловсролтой / инженерийн зохиох боловсролтой;

• Магистраас дээш боловсролтой;

• Цэргийн анги байгууллагад тасралтгүй 5-аас доошгүй, төрийн албанд 8-аас доошгүй жил ажилласан байх;

• Орос хэлийг хүрээнд мэргэжлийн түвшинд эзэмшсэн, англи хэлний зохиох боловсролтой байх.

Бүрдүүлэх материал:

• Өргөдөл;
• Төрийн алба хаагчийн анкет (1 дүгээр маягтаар);

• Боловсролын зэргийг гэрчилсэн баримт (дипломууд);

• Иргэний болон офицерын үнэмлэхийн хуулбар;

• Цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

• Сонгон шалгаруулалтад орохыг зөвшөөрсөн ажиллаж буй байгууллагын бичгээр гарсан зөвшөөрөл;

• Бүртгэлийн хураамж /тухай бүрд тогтоон зарлана/;
• Бусад шаардлагатай бичиг баримт.

2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хүртэл ҮБХИС-ийн штабын 3 дугаар давхар, 303 тоот өрөөнд явагдана.

Холбогдох албан тушаалтан:

БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Т.Соронзонболд, Референт-Эрдэм шинжилгээний ажилтан, ахмад Ж.Базарсүрэн. Утас: 453942, 90881133

Бүртгэл:

Фото агшин



Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ